

ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН – ОРХОН АЙМАГ

Орхон аймаг

2025.12.15

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Орхон аймгийн хэмжээнд 2025 онд эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, удирдлага зохион байгуулалтыг оновчтой болгох зорилгоор Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан 1313.мн-д 2025 онд бүртгэгдсэн хэрэглэгчийн үнэлгээ буюу эрүүл мэндийн байгууллагын үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд үнэлгээ хийлээ. ЭМХТөвийн 2025 оны 11 сарын 17-ны 1222 тоот албан тоотой Орхон аймгийн 2024 онд ашигласан ор, амбулаторийн үйлчлүүлэгчийн тооноос түүвэрлэн 2025 оны хэрэглэгчийн үнэлгээнд амбулатори-264, хэвтэн 220 нийт 484 үйлчлүүлэгчийг хамруулах боломжтой гэж ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд 1366 хүн Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан **1313.мн-д** хэрэглэгчийн үнэлгээнд хандсанаас Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөр үйлчлүүлсэн 535 буюу 39,1%, өрхийн эрүүл мэндийн 8 төвөөс 831 буюу 60,8% -ийг тус тус эзлэж байна. Үүнээс амбулаторит 1110 буюу 81,2%, хэвтэн үйлчлүүлэгч 254 хүн буюу 18,8% нь сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан байна. Нийт судалгаанд хамрагдсан 1366 үйлчлүүлэгчээс 2025 оны эхний хагас жилд 625 буюу 45,7%, 2025 оны сүүлийн хагас жилд 741 буюу 54,3 % нь хамрагдсан байна.

Хүснэгт.1. Нийт үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоог харуулбал:

№	Эрүүл мэндийн байгууллагууд	2025 оны эхний хагас жил		2025 оны сүүлийн хагас жил		Нийт
		Амбулатори	Хэвтэн	Амбулатори	Хэвтэн	
1	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	134	74	145	182	535
2	Үйлсбадрах ӨЭМТ	-	-	144	-	144
3	Мэндцэцэн	54	-	93	-	147
4	Анхны оч	29	-	53	-	82
5	Энхжихмандариваа	46	-	40	-	86
6	Мөнхсүндрэл	177	-	31	-	208
7	Мөнхийн гэгээ	3	-	28	-	31
8	Учралтбаяр	20	-	20	-	40
9	Нийцэл	88	-	5	-	93
10	Бүгд	551	74	559	182	1366


Нэг.Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан 1313.мн-ээр амбулаториор хийгдсэн асуумжийн дагуу үйлчлүүлэгчийн хэрэглэгчийн үнэлгээний судалгаа:

1. Таны хүйс:Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчийн хүйсийн хувьд эмэгтэй 70,2%, эрэгтэй-30,0% эзлэж байна.

2.Таны нас: Үйлчлүүлэгчийн насны хувьд 18-25 нас 15,8%, 26-35 нас-25,0%, 36-45 нас 25,0%,36-45 нас 25,0%, 45-55 нас 23,1%, 56-аас дээш 11,9% -ийг тус тус эзлэж байна.

3.Эмчид үзүүлэхдээ хүлээсэн хугацаа: Тэр өдөртөө-91,9%, 7 хоног хүртэл-7,2%, 1 сараас дээш хүлээсэн-0,9% гэж судалгаанд оролцогч нар хариулсан байна.


Зураг.1. Эмчид үзүүлэхдээ хүлээсэн хугацаа:



4.Эмнэлгийн цагийн мэдээлэл, цаг авахад хялбар байсан уу?

Эмнэлгийн цагийн мэдээлэл, цаг авахад хялбар байсан уу гэсэн асуумжид үйлчлүүлэгч нар Тийм -94,7%, Үгүй-3,8%, Ойлгомжгүй-1,4% гэж тус тус хариулсан байна.


Зураг 2. Эмнэлгийн цагийн мэдээлэл, цаг авахад хялбар байсан уу?



5.Бүртгэл мэдээллийн ажилтны харилцаа хандлагыг үнэлнэ үү

Судалгаанд оролцогч нар бүртгэл мэдээллийн ажилтны харилцаа хандлагыг үнэлнэ үү гэсэн асуумжид Маш сайн -46,2%, Сайн-45,6%, Дунд-6,5%, Муу-0,6% гэж тус тус хариулсан байна.


Зураг 3. Бүртгэл мэдээллийн ажилтны харилцаа хандлагыг үнэлнэ үү



6.Сувилагчдын харилцаа,хандлага, танд анхаарал хандуулсан байдлыг үнэлнэ үү

Сувилагчдын харилцаа,хандлага, танд анхаарал хандуулсан байдлыг үнэлнэ үү гэсэн асуумжид Маш сайн-49,4%, Сайн-44,1%, Дунд-5,0%, Муу-0,6% гэж оролцогч нар хариулсан байна.


Зураг.4. Сувилагчдын харилцаа,хандлага, танд анхаарал хандуулсан байдлыг үнэлнэ үү



7. Эмч нарын мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлагын байдлыг үнэлнэ үү


Судалгаанд оролцогч нар эмч нарын мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлагын байдлыг үнэлнэ үү гэсэн асуумжид Маш сайн -48,3%, Сайн-45,2%, Дунд-5,2%, Огт хангалтгүй-0,39% гэж тус тус хариулсан байна.

Зураг. 5.Эмч нарын мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлагын байдлыг үнэлнэ үү



8. Оношилгоо эмчилгээний талаарх мэдээллийн ойлгомжтой байдлыг үнэлнэ үү
 Оношилгоо эмчилгээний талаарх мэдээллийн ойлгомжтой байдлыг үнэлнэ үү гэсэн асуумжид оролцогч нар Маш хангалттай-45,4%, Хангалттай-46,9%,Дунд-6,4%, Огт хангалтгүй-0,36% гэж тус тус хариулсан байна.


Зураг 6. Оношилгоо эмчилгээний талаарх мэдээллийн ойлгомжтой байдлыг үнэлнэ үү



9.Эмнэлгийн орчны цэвэр,тав тухтай байдлыг үнэлнэ үү?

Судалгаанд оролцогч нар эмнэлгийн орчны цэвэр,тав тухтай байдлыг үнэлнэ үү? гэсэн асуумжид Маш сайн-48,4%,Сайн-45,2%,Дунд-5,4%,Муу-0,56% гэсэн хариултыг тус тус хариулсан байна.


Зураг 7. Эмнэлгийн орчны цэвэр,тав тухтай байдлыг үнэлнэ үү?



10.Эмнэлгийн ариун цэврийн өрөө хангалттай цэвэр байсан уу?

Эмнэлгийн ариун цэврийн өрөө хангалттай цэвэр байсан уу? гэсэн асуумжид Маш сайн-44,0%, сайн-45,4%, Дунд-8,4%, Муу-1,4% гэсэн хариултыг тус тус өгсөн байна.

Зураг 8. Эмнэлгийн ариун цэврийн өрөө хангалттай цэвэр байсан уу?



11.Эмчилгээ танд үр дүнтэй санагдсан уу ?

Эмчилгээ танд үр дүнтэй санагдсан уу ? гэсэн асуумжид Маш хангалттай-45,1%, Хангалттай-48,4%, Дунд-5,4%, Огт хангалтгүй-0,3% гэж тус тус хариулсан байна.


Зураг 9. Эмчилгээ танд үр дүнтэй санагдсан уу ?



12.Та тус эмнэлгийн үйлчилгээг бусдад санал болгох уу?

Та тус эмнэлгийн үйлчилгээг бусдад санал болгох уу?гэсэн асуумжид Тийм -90,7%, Үгүй-5,1%, Эргэлзэж байна-4,2% гэж тус тус хариулсан байна.

Зураг.10. Та тус эмнэлгийн үйлчилгээг бусдад санал болгох уу?




Хоёр.Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан 1313.тн-ээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хэвтэн эмчлүүлэгчийн асуумжаар хийгдсэн хэрэглэгчийн үнэлгээний судалгаа :

1.Таны хүйс:Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчийн хүйсийн хувьд эмэгтэй -70,2%, эрэгтэй-30,0% эзлэж байна.

2.Таны нас: Үйлчлүүлэгчийн насны хувьд 18-25 нас-17,0%, 26-35 нас -26,0%, 36-45 нас 23,0%, 45-55 нас 19,2%, 56-аас дээш 14,8 %–ийг тус тус эзлэж байна.

3.Эмчид үзүүлэхэд хүлээсэн хугацаагаар 5 хоног хүлээсэн 12,9%, 7 хоног хүлээсэн 51,6%-ийг эзлэж байна.


Хүснэгт 2.Эмчид үзүүлэхэд хүлээсэн хугацаа/хоногоор/



4.Эмнэлгийн цагийн мэдээлэл,цаг авахад хялбар байсан уу ?

Судалгаагаар эмнэлгийн цагийн мэдээлэл,цаг авахад хялбар байсан уу гэсэн асуумжид үйлчлүүлэгч нар тэр өдөртөө л мэдээлэл цаг авахад хялбар байсан 67,1%, 3 хоногийн дараа 18,0%, 7-14 хоногийн дараа 10,6%, 15-30 хоног 2,6%, 1 сарын дараа 1,8% эзлэж байна.


Зураг.1. Эмнэлгийн цагийн мэдээлэл,цаг авахад хялбар байсан эсэх



5.Бүртгэл мэдээллийн ажилтны харьцаа хандлагыг үнэлнэ үү ?

Судалгаанд оролцогч нар бүртгэл мэдээллийн ажилтны харьцаа хандлагыг Маш сайн -36,7%, Сайн-53,3%, Дунд зэрэг-8,34%, Муу-0,69% -иар тус тус үнэлсэн байна.


Зураг 2. Бүртгэл мэдээллийн ажилтны харьцаа хандлагыг үнэлнэ үү



6.Сувилагчдын харилцаа хандлага, танд анхаарал хандуулсан байдлыг үнэлнэ үү ?

Судалгаанд оролцогч нар сувилагчдын харилцаа хандлага, танд анхаарал хандуулсан байдлыг Маш сайн-46,0%, Сайн-46,8%, Дунд -6,1%, Муу -0,4% тус тус үнэлсэн байна.

Зураг 3. Сувилагчдын харилцаа хандлага, танд анхаарал хандуулсан байдлыг үнэлнэ үү



7.Эмч нарын мэргэжлийн ур чадвар, харилцаа мэдээлэл өгөх байдлыг үнэлнэ үү ?

Эмч нарын мэргэжлийн ур чадвар, харилцаа мэдээлэл өгөх байдлыг судалгаанд оролцогч нар Маш хангалттай-42,4%, Хангалттай-49,6%, Дунд зэрэг-6,7%,Огт хангалтгүй-0,4% гэж үнэлсэн байна.


Зураг 4. Эмч нарын мэргэжлийн ур чадвар, харилцаа мэдээлэл өгөх байдлыг үнэлнэ үү



8.Оношилгоо эмчилгээний талаарх мэдээллийн ойлгомжтой байдлыг үнэлнэ үү

Судалгаанд оролцогч нар оношилгоо эмчилгээний талаарх мэдээллийн ойлгомжтой байдлыг Маш хангалттай 34,7%, Хангалттай 54,6%, Дунд 9,2%, Огт хангалтгүй-0,39% гэж тус тус үнэлсэн байна.

Зураг.5 Оношилгоо эмчилгээний талаарх мэдээллийн ойлгомжтой байдлыг үнэлнэ үү




9.Эмнэлгийн орчны цэвэр, тав тухтай байдлыг үнэлнэ үү

Эмнэлгийн орчны цэвэр, тав тухтай байдлыг Маш сайн-38,1%, Сайн-50,0%, Дунд-10,1%,

Муу-0,9% гэж судалгаанд оролцсон үйлчлүүлэгч нар үнэлсэн байна.


Зураг. 6. Эмнэлгийн орчны цэвэр, тав тухтай байдлыг үнэлнэ үү



10.Эмнэлгийн ариун цэврийн өрөө, тав тухтай байдлыг үнэлнэ үү ?

Эмнэлгийн ариун цэврийн өрөө, тав тухтай байдлыг Маш сайн -32,9%, Сайн-47,9%, Дунд-15,4%, Муу-2,5%, Маш муу-1,1% гэж судалгаанд оролцсон үйлчлүүлэгч нар тус тус үнэлсэн байна.


Зураг.7. Эмнэлгийн ариун цэврийн өрөө, тав тухтай байдлыг үнэлнэ үү



11.Эмчилгээ танд үр дүнтэй санагдсан уу ?

Судалгаанд оролцогч нар Эмчилгээ танд үр дүнтэй санагдсан уу? гэсэн асуултад Маш сайн-34,0%, Сайн-49,4%, Дунд-13,6% Муу-2,0% гэж тус тус хариулсан байна.


Зураг 8. Эмчилгээ танд үр дүнтэй санагдсан уу ?



12.Та тус эмнэлгийн үйлчилгээг бусдад санал болгох уу ?

Та тус эмнэлгийн үйлчилгээг бусдад санал болгох уу ? асуултад Тийм 90,2%, Үгүй-9,7% гэж тус тус судалгаанд оролцогч нар хариулсан байна.

Зураг.9. Та тус эмнэлгийн үйлчилгээг бусдад санал болгох уу




Гурав.Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан 1313.mn-д 2025 онд бүртгэгдсэн хэрэглэгчийн үнэлгээний дүнг хамрагдсан байгууллагуудад үнэлгээ хийсэн байдал:

Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан 1313.mn-д 2025 онд бүртгэгдсэн хэрэглэгчийн үнэлгээнд 1366 хүн хамрагдаж, хэрэглэгчээс өгсөн үнэлгээ 4,0-4,8 гэсэн онооны хооронд хэлбэлзэж,4.8 буюу өндөр үнэлгээг Мөнхсүндрэл, хамгийн бага буюу 4.0 оноог Бүсийн оношилгоо эмчилгээний төв авсан байна.

Тус хэрэглэгчийн үнэлгээнд нийт 9 байгууллага оролцсоноос БОЭТ, өрхийн эрүүл мэндийн 8 төв 100% тус судалгаанд хамрагдсан байна. Үүнд: Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөр үйлчлүүлсэн 141 буюу 29,0%, 8 өрхийн эрүүл мэндийн төвөөс 338 буюу 71,0% -ийг тус тус эзлэж байна.

Хүснэгт.1. Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан 1313.mn-д 2025 онд бүртгэгдсэн хэрэглэгчийн үнэлгээний дүнг хамрагдсан байгууллагуудын үнэлгээг харуулбал :



ДҮГНЭЛТ :

Нэг.Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан 1313.mn-ээр амбулаториор хийгдсэн 12 асуумжийн дагуу үйлчлүүлэгчийн хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд 831 хүн оролцсоноос хүйсийн хувьд эмэгтэй 70,2%, эрэгтэй-30,0% эзлэж, насны хувьд 18-25 нас 15,8%, 26-35 нас-25,0%, 36-45 нас 25,0%,36-45 нас 25,0%, 45-55 нас 23,1%, 56-аас дээш 11,9% байна.

Эмчид үзүүлэхдээ хүлээсэн хугацаагаар өдөртөө-91,9%, 7 хоног хүртэл-7,2%, 1 сараас дээш хүлээсэн-0,9% гэж судалгаанд оролцогч нар хариулсан байна. Эмнэлгийн цагийн мэдээлэл, цаг авахад хялбар байсан уу гэсэн асуумжид Тийм -94,7%, Үгүй-3,8%, Ойлгомжгүй-1,4%, Бүртгэл мэдээллийн ажилтны харилцаа хандлагыг Маш сайн -46,2%, Сайн-45,6%, Дунд-6,5%, Муу-0,6% гэж үнэлсэн байна.

Сувилагчдын харилцаа,хандлага, танд анхаарал хандуулсан байдлыг Маш сайн-49,4%, Сайн-44,1%, Дунд-5,0%, Муу-0,6%, Эмч нарын мэргэжлийн ур чадвар, харилцаа хандлагын байдлыг Маш сайн -48,3%, Сайн-45,2%, Дунд-5,2%, Огт хангалтгүй-0,39% гэж тус тус үнэлсэн байна.

Оношилгоо эмчилгээний талаарх мэдээллийн ойлгомжтой байдлыг Маш хангалттай-45,4%, Хангалттай-46,9%,Дунд-6,4%,Огт хангалтгүй-0,36%, Эмнэлгийн орчны цэвэр, тав тухтай байдлыг Маш сайн-48,4%,Сайн-45,2%,Дунд-5,4%,Муу-0,56% гэсэн бол эмнэлгийн ариун цэврийн өрөө хангалттай цэвэр байсан эсэхэд Маш сайн-44,0%, сайн-45,4%, Дунд-8,4%, Муу-1,4%

Эмчилгээ танд үр дүнтэй санагдсан эсэхэд Маш хангалттай-45,1%, Хангалттай-48,4%, Дунд-5,4%, Огт хангалтгүй-0,3%, Та тус эмнэлгийн үйлчилгээг бусдад санал болгох уу?гэсэн асуумжид Тийм -90,7%, Үгүй-5,1%, Эргэлзэж байна-4,2% гэж тус тус үнэлсэн байна.

Хоёр.Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан 1313.mn-ээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хэвтэн эмчлүүлэгчийн асуумжаар хийгдсэн хэрэглэгчийн

үнэлгээний судалгаанд 12 асуумжаар 535 үйлчлүүлэгч оролцоноос хүйсийн хувьд эмэгтэй -70,2%, эрэгтэй-30,0% эзлэж, үйлчлүүлэгчийн насны хувьд 18-25 нас-17,0%, 26-35 нас -26,0%, 36-45 нас 23,0%, 45-55 нас 19,2%, 56-аас дээш 14,8 % байна.

Эмчид үзүүлэхэд хүлээсэн хугацаагаар 5 хоног хүлээсэн 12,9%, 7 хоног хүлээсэн 51,6%-ийг эзлэж байна.

Эмнэлгийн цагийн мэдээлэл, цаг авахад хялбар байсан эсэхэд Өдөртөө л мэдээлэл цаг авахад хялбар байсан 67,1%, 3 хоногийн дараа 18,0%, 7-14 хоногийн дараа 10,6%, 15-30 хоног 2,6%, 1 сарын дараа 1,8% гэж үнэлсэн байна.

Бүртгэл мэдээллийн ажилтны харьцаа хандлагыг Маш сайн -36,7%, Сайн-53,3%, Дунд зэрэг-8,34%, Муу-0,69%, Сувилагчдын харилцаа хандлага, танд анхаарал хандуулсан байдлыг Маш сайн-46,0%, Сайн-46,8%, Дунд -6,1%, Муу -0,4% гэж үнэлсэн байна.

Эмч нарын мэргэжлийн ур чадвар, харилцаа мэдээлэл өгөх байдлыг судалгаанд оролцогч нар Маш хангалттай-42,4%, Хангалттай-49,6%, Дунд зэрэг-6,7%, Огт хангалтгүй-0,4% гэж үнэлсэн байна.

Оношилгоо эмчилгээний талаарх мэдээллийн ойлгомжтой байдлыг Маш хангалттай 34,7%, Хангалттай 54,6%, Дунд 9,2%, Огт хангалтгүй-0,39%, Эмнэлгийн орчны цэвэр, тав тухтай байдлыг Маш сайн-38,1%, Сайн-50,0%, Дунд-10,1%, Муу-0,9% , Эмнэлгийн ариун цэврийн өрөө, тав тухтай байдлыг Маш сайн -32,9%, Сайн-47,9%, Дунд-15,4%, Муу-2,5%, Маш муу-1,1% гэж тус тус үнэлэгдсэн байна.

Эмчилгээ танд үр дүнтэй санагдсан уу? гэсэн асуултад Маш сайн-34,0%, Сайн-49,4%, Дунд-13,6% Муу-2,0% , Та тус эмнэлгийн үйлчилгээг бусдад санал болгох эсэхэд Тийм 90,2%, Үгүй-9,7% нь тус тус үнэлсэн байна.

Гурав. Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан 1313.mn-д 2025 онд бүртгэгдсэн хэрэглэгчийн үнэлгээнд 1366 хүн хамрагдаж, хэрэглэгчээс өгсөн үнэлгээ 4,0-4,8 гэсэн онооны хооронд хэлбэлзэж, 4.8 буюу өндөр үнэлгээг Мөнхсүндрэл, хамгийн бага буюу 4.0 оноог Бүсийн оношилгоо эмчилгээний төв авсан бөгөөд Эрүүл мэндийн 9 байгууллагын дундаж үнэлгээ нь 4.4-тэй байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ:

1. Хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдсан 1366 үйлчлүүлэгчийн ерөнхий сэтгэл ханамжийн дундаж 90,7%-тай үнэлэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 5,6%-иар нэмэгдсэн байна.

2. ЭМБ-уудын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бүртгэл мэдээллийн ажилтны харьцаа хандлагын дундаж хувь 91,7%-тай үнэлэгдсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 1,4%-иар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

3. Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн 12 байгууллагын байгууллагын дотоод орчны талаарх сэтгэл ханамжийн түвшин 90,5% буюу сэтгэл ханамж "Маш сайн" гэсэн үнэлгээг 43,2%-тай авсан байна.

4. Тусламж үйлчилгээний хүлээгдлийн хувьд амбулаторит эхний өдөртөө үзүүлсэн-91,9%-тай, харин БОЭТ-д хэвтэн эмчлүүлэхэд 5-7 хүртэл хоногийн хүлээгдэл 64,5%-ийг эзлэж байгаа тул цаашид БОЭТ-ийн хүлээгдэл, ачааллыг тасаг нэгжээр гарган хариу арга хэмжээг авах зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

5. Амбулаторит үйлчлүүлэгчийн цагийн мэдээлэл, цаг авахад хялбар байсан 94,7%, харин БОЭТ-д хэвтэн эмчлүүлэхэд 67,1%-тай байгаа тул цаашид БОЭТ-ийн цаг товллын үйлчилгээг сайжруулах, хүлээгдлийг бууруулах талаар хариу арга хэмжээг зохион байгуулах зөвлөмжийг хүргүүлэх

6. Эрүүл мэндийн байгууллагаас авч байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлын талаарх үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн түвшин 90,4%-тай байна.

7. Үйлчлүүлэгчийн эмчилгээний үр дүнгийн талаархи үнэлгээний дундаж 86,4%-тай байна. Иймд цаашид үйлчлүүлэгчдэд хийгдэж байгаа эмчилгээний талаархи ойлголтыг түлхүү өгөхөд ЭМБ-уудын удирдлага, Эмчилгээ чанарын баг, албаны зүгээс анхаарч хариу арга хэмжээг зохион байгуулах

8. ЭМБ-уудаас хэрэглэгчийн үнэлгээнд хамрагдах үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тогтмол үнэлж, хариу арга хэмжээг авах хэрэгцээтэй байна.

Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүн :

1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах

хүрээнд бүх шатлалын Эрүүл мэндийн байгууллагуудын дунд “Үйлчлүүлэгч ба үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулъя” аян 1, салбар дундын байгууллагуудын хурал 84 удаа, чанарын өдөрлөг 4, хэлэлцүүлэг 18, дэмжлэгт хяналт, үнэлгээ 64, эмнэлзүйн сургалт 26, туршлага солилцох уулзалт 12 удаа зохион байгуулж, “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартын хэрэгжилт дунджаар 85,8%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,3%-иар нэмэгдэн, үйлчлүүлэгчдэд ээлтэй, тав тухтай орчинг бүрдүүлсэн байна.

2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн хэрэгжилтийг тогтмол үнэлэн 2025 оны эхний хагас жилд доголдож байсан 5, анхаарах 8 үзүүлэлтийг сайжруулах төлөвлөгөөний дагуу хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр дээрхи 13 үзүүлэлтийн гүйцэтгэл сайжирч, хүрэх түвшинд хүрсэн байна.

3. 2025 онд Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг 5 өрхийн эрүүл мэндийн төв нэвтрүүлснээр анхан шатны 8 эрүүл мэндийн байгууллагууд ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог 100% нэвтрүүлсэн нь өмнөх оноос 62.5%-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна.

4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааг дэмжих, ёс зүй харилцаа хандлага, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр “Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжил, хөтөлбөр”-ийн 120,0 сая төгрөгийн санхүүжилтээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, алдаршуулах, хөгжүүлэх 12 удаагийн арга хэмжээ, хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн 112 удаагийн сургалтад 2075 эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон 60 гаруй эмчийг төрөлжсөн болон гадаад сургалтад хамруулан эрүүл мэндийн салбарын тогтвортой сэтгэл зүйтэй хамт олныг бүрдүүлэх “Сэтгэл зүйн дархлаатай хамт олон” төсөлд 11 эрүүл мэндийн байгууллагын 968 эмч, мэргэжилтнийг чадавхжуулан 11 ментор албан хаагчийг бэлтгэсэн байна.

5. 2025 онд Эрүүл мэндийн салбарт нийт 7 тэрбум 167,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс улсын төсөв 28,7%, орон нутаг 70,8%, олон улсын төсөл хөтөлбөр 0,5% -ийг зарцуулсан байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтад нийт 5.5 тэрбум төгрөг батлагдсан нь өмнөх онтой харьцуулахад 8,4% -иар нэмэгдэж, эрүүл мэндийн байгууллагуудын их засварт 1.642.6 тэрбум буюу 32,8%, багаж тоног төхөөрөмжийн хангалтад 1.104.0 тэрбум буюу 21,7%, төсөл хөтөлбөрт 2.3 тэрбум төгрөг буюу 45,5 %-ийг тус тус эзэлж байна. Ингэснээр анхан шатлалын Эрүүл мэндийн байгууллагуудын багаж тоног төхөөрөмжийн хангалт 92.5%, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 96%-д хүрч, үүнээс 20.1% нь дэвшилтэт технологийг нэвтрүүлэхээр хангагдсан бөгөөд орон нутагт Харвалт шигдээс, дурангийн хагалгаа, оношилгоонуудыг амжилттай нутагшуулан эрт илрүүлэг үзлэг, Хавдрын тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, лавлагаа шатлалд явах урсгалыг 30%-иар бууруулан хүн амын дундаж наслалт 0.32-аар нэмэгдсэн байна.

6. Эрүүл мэндийн байгууллагуудын вебсайт, FB хуудас, мэдээллийн самбарт цаг үеийн болон холбогдох мэдээ мэдээллийг байршуулж сурталчилан мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.

7.Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Бүсийн оношилгоо эмчилгээний төв, 8 өрхийн эрүүл мэндийн төв, Хувийн хэвшлийн 11 ортой клиникүүдтэй Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга хамтын гэрээ байгуулан урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, шалгуур үзүүлэлтийг сар, улирал, хагас ,бүтэн жилээр дүгнэж, тулгамдаж байгаа асуудлыг эрэмбэлэн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэн, явцын хяналт 24 удаа, ЭМГ-ын даргын тойрон үзлэгийг 1 удаа хийж, гэрээний хэрэгжилтийн үнэлгээний дундаж 91,5%-тэй хэрэгжсэн байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1,1 %-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна.

Зөвлөмж:

1.Хүн амын дунд эрүүл мэндийн тэгш байдлын судалгааг хийж, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тохирсон хариу арга хэмжээг авч ажиллах

2.Эрүүл мэндийн статистикийн нэгдсэн сан 1313.mn-д хандах хэрэглэгчийн үнэлгээг нэмэгдүүлж,“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага”MNS7014:2023 стандартын хэрэгжилтийг сайжруулан, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах

3.ЭМС-ын 2021 оны А/578 дугаар тушаалын дагуу өөрийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хариу арга хэмжээг авч,үр дүнг тооцох

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ

ТАНИЛЦУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ

ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ

лавлагаа шатлалд явах урсгалыг 25,0%-иар бууруулсан байна. Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар БОЭТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын үзүүлэлтүүд дунджаар 85.8%, эмнэлгийн тусламж үйлчилгээнд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 92,4%-тай байна.

1. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн ортой клиникүүдийн 85,6%-д урсгал засвар хийгдэн, үйлчлүүлэгчийн ая тухтай ээлтэй орчныг бүрдүүлсэн бөгөөд стандартын дагуу багаж тоног төхөөрөмжийн хангалт 98,0%, хүний нөөцийн хангалт 87,5%, их эмч хангалттай ч төрөлжсөн мэргэжлийн эмч ,сувилагч дутагдалтай, эмч сувилагчийн харьцаа 1:1,4 байна. 2023 онд хувийн хэвшлийн ортой 6 клиник магадлан итгэмжлэлд хамрагдсанаар нийт хувийн хэвшлийн ор бүхий клиникийн 88,9% магадлан итгэмжлэлд хамрагдан эрүүл мэндийн даатгалаас хэвтүүлэн эмчлэх, өдрийн эмчилгээ, амбулаторийн үзлэгээр санхүүжилтийг авч иргэдээс төлбөр авалт буурснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдэн 89,0%-д хүрээд байна.
2. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн салбарт Эмчилгээ чанарын 3 алба, 55 баг ажиллаж, 100% байгууллагын даргын тушаалаар байгуулагдан чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 90%, 2023 оны эмнэлгийн тусламжийн чанарын үзүүлэлт 78,3%- тай үнэлэгдсэн бөгөөд чанарын албаны хурал 52, дотоод хяналт 84, ижил мэргэжилтний үзлэг 18 чиглэлээр 136 удаа хийж, тусламж үйлчилгээтэй холбоотой 84 тохиолдол бүртгэн эмнэлзүйн конференци 5, ховор тохиолдлын хэлэлцүүлэг 5, мэс заслын дараах хүндрэл 10, эхний ноцтой хүндрэл 2, нас баралтын 56 тохиолдлыг хэлэлцсэн байна. Эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийг сайжруулах хүрээнд салбар дундын 4 удаагийн хэлэлцүүлэг, төвийн болон дотоодын 36 удаагийн сургалт, бүсийн чуулга уулзалт 2, яаралтай амилуулах суурь тусламжийн ажил мэргэжлийн уралдаан 1, сувилахуйн чиглэлээр гардан үйлдлийн түвшинг үнэлэн зохион байгуулж давхардсан тоогоор 712 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан байна.
3. Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг бүртгэх eburtgel.moh.gov.mn системийг ЭМХТ-өөс шинээр нэвтрүүлэн, анхан шат, лавлагаа шатны, ор бүхий хувийн хэвшлийн клиникүүд нийт 18 байгууллага бүртгэлээ үүсгэн eburtgel.moh.gov.mn цахим программд тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлыг бүртгүүлж хэвшсэн ба Эрүүл мэндийн газраас программын бүртгэл, хариу арга хэмжээний хэрэгжилтийн байдалд тогтмол хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд бүртгэгдсэн 84 тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлоос эмнэлзүйн шалтгаан 48,6%, эмнэлзүйн бус шалтгаан 44 бүртгэгдсэн байна. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг sudalгаа.1313.mn цахим системээр Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд QR код үүсгэн, байршуулж, үйлчлүүлэгч иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч, судалгаанд хамрагдсан хүний тоо 928 байна. Эрүүл мэндийн

байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг sudalгаа.1313.mn цахим системээр Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд QR код үүсгэн байршуулж, үйлчлүүлэгч иргэдийг сэтгэл ханамжийн судалгаанд хамруулсан.Тус судалгаагаар тайлант хугацаанд хэвтэн эмчлүүлсэн 82 иргэний эмнэлгийн тусламж үйлчилгээний сэтгэл ханамж маш сайн гэж 40,2%, сайн гэж 51,2% нь хариулсан байна. Амбулаториор үйлчлүүлсэн 1055 иргэний эмнэлгийн тусламж үйлчилгээний сэтгэл ханамж маш сайн гэж 52,79%, сайн гэж 28,37% нь үнэлсэн байна.

4. Тайлант хугацаанд тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж, хариу арга хэмжээний чадавх нэмэгдүүлэх хүрээнд орон нутгийн төсвөөс 25.0 сая төгрөгийг шийдвэрлэснээр эрүүл мэндийн байгууллагуудад дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хариуцсан 40 мэргэжилтэн бэлтгэгдэж, эрүүл мэндийн 3 байгууллагад олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001 стандарт эрсдэлийн менежментийн тогтолцоо ISO31000:2018 стандарт нэвтрэн, томуу, томуу төст өвчний дэгдэлтийг хүндрэл бэрхшээлгүй даван туулсан.
5. Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудад өгч, 2 удаагийн сургалтад 49 хүнийг хамруулж, 199 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, удирдлагад мэдээлэл хүргэн ажилласан.

ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААГ НЭГТГЭСЭН:

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН ЧАНАР, ЭРСДЭЛ, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН П.ХИШГЭЭ